



Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн үр нөлөөт байдал

**ХҮҮХДИЙН ТООНЫ ДАВХАРДЛААС ОЙРОЛЦООГООР  
ТАВАН СУРГУУЛИЙН ХУВЬСАХ ЗАРДАЛТАЙ  
ТЭНЦЭХҮЙЦ ХӨРӨНГИЙГ ҮРГҮЙ ЗАРЦУУЛЖ БАЙНА**

# АГУУЛГА

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	<i>Товчилсон үгсийн жагсаалт .....</i>	3
<b>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</b>	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....</i>	4
Газрын захирал: Д.Ганбилэг	<b>Бүлэг 1: Сургууль, цэцэрлэгүүд хүүхдийн тоог өсгөж төлөвлөдөгөөс жилд ойролцоогоор 5 сургуулийн хувьсах зардалтай тэнцэх хэмжээний хөрөнгийг үргүй зарцуулж байна</b>	
Аудитын менежер: Х.Баярмаа	• <i>Ерөнхий зүйл</i>	5
Ахлах аудитор: Ц.Гэрэл	• <i>Төлөвлөлтийн эрх зүйн үндэслэл</i>	5
Аудитор: Д.Болормаа	• <i>Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг хувьсах зардлын нормативаар төлөвлөдөг ч Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль болон төсвийн тодотголоор бууруулдаг нь түүнийг ач холбогдолгүй болгож байна</i>	6
Шинжээч: У.Баярмаа	• <i>Нэг багшид дунджаар 20 хүүхэд ногдож байна</i>	7
Б.Саруул	• <i>Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг урсгал зардалд зарцуулжээ</i>	9
Ш.Энхтайван	• <i>Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарт олгох тэтгэмжийн төсвийг батлуулаагүйгээс Үдийн цайны болон тогтмол зардлаас нөхжээ</i>	10
<b>Нийслэл, аймгийн аудитын газрууд</b>	• <i>Үр дүнгийн урамшууллыг зориулалт бусаар зарцуулсан байна</i>	10
<b>2010 оны 6 дугаар сар</b>	• <i>Гүнзгийрүүлсэн сургалт явуулах төлбөрийн хэмжээгээр төсвөөс олгох санхүүжилтийг бууруулсан нь Боловсролын тухай хуулийг зөрчсөн байна</i>	11
<b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</b>	• <i>Засаг даргын захирамжаар боловсролын төсвөөс санхүүжүүлж гадаадад явуулжээ</i>	11
<a href="http://www.mnao.mn">www.mnao.mn</a>	• <i>Боловсролын газар төсвийн хуваарийг удаа дараа өөрчилсөн байна</i>	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	• <i>ЕБС-ийн дотуур байрны хоолны зардлын норматив, шаардагдах илчлэгийн хэмжээ уялдаа муу байна</i>	12
.	• <i>Хүүхдийн тоог өсгөж төлөвлөснөөс хоолны зардлын хэмнэлт гарч бусад зардалд шилжүүлэн зарцуулжээ</i>	13
<b>ХАЯГ:</b>	• <i>Тогтмол зардлыг бодитой төлөвлөөгүй байна</i>	13
Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	• <i>Тогтмол зардлын үнийн өсөлт төсөв хэтрэх нөхцөл үүсгэж байна</i>	14
	• <i>Сургуулиудын сурах орчин муу, хичээлийн байрны багтаамж хүрэлцээгүй байна</i>	14
	• <i>Боловсролын салбарт санхүүгийн дотоод хяналт үр нөлөөгүй байна</i>	15

<b>Бүлэг 2: Төсвийн хөрөнгөөр 2009-2010 оны хичээлийн жилд 5270 нарийн бичиг, бичиг хэргийн ажилтан гэх мэтийн чухал шаардлагагүй мэргэжилтэн бэлтгэж байгаа нь МСҮТ-ийн нийт суралцагчдын 11.8 хувийг эзэлж байна</b>	
• Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулаагүй байна	16
• Хувьсах зардлын нормативыг мэргэжлийн чиглэлээр тогтоогоогүй нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцаа алдагдахад нөлөөлж байна	17
• Шинээр байгуулах “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан”-г, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-тай уялдуулж болохоор байна	18
• МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох тухай журам тодорхой бус байна	19
• Боловсролын салбарын төсвийн хэмнэлтийн журам хүүхдийн тоог өсгөж төлөвлөх сонирхол төрүүлэхүйц болжээ	19
<b>Дүгнэлт:</b> .....	21
<b>Зөвлөмж:</b> .....	22
<b>Холбогдох байгууллагын санал</b>	23
<b>ҮАГ-ын тайлбар</b>	25
<b>Хавсралтууд:</b>	
Хавсралт-1 : ЕБС-уудын 2009 оны санхүүжилтийн судалгаа	26
Хавсралт-2 : ЕБС-иудын 2009 оны хүүхдийн тооны төлөвлөлтийн судалгаа	27
<b>Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал</b>	28

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БСГ	Боловсрол соёлын газар
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХД	Багахангай дүүрэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
МБСГ	Мэргэжлийн боловсрол сургалтын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НД	Налайх дүүрэг
НХХ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөр
СБД	Сүхбаатар дүүрэг
СТС	Сургалтын төрийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ШУБС	Шинжлэх ухаан, боловсролын сан
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт**

Боловсролын салбарын төсвийг төлөвлөх, зардлыг санхүүжүүлэх үйл ажиллагаа үр нөлөөтэй эсэхийг шалгаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Энэ зорилтын хүрээнд дараахь чиглэлээр аудит хийв. Үүнд:

- ✓ Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт үндэслэлтэй эсэх
- ✓ Боловсролын салбарын санхүүжилтийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх

### **Хамарсан хүрээ**

Аудитад БСШУЯ, түүний харъяа төв, орон нутгийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын зарим байгууллагууд, НБГ, МСҮТ болон холбогдох бусад байгууллагууд хамрагдлаа.

### **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Сурагчдын тооны бүртгэлийг төлөвлөсөн бүртгэлтэй харьцуулах, суралцагчдын хувийн хэргийг тоолох, тулгах болон журналын нэрсийн тоог төлөвлөсөн тоотой харьцуулах, улсын хэмжээний сурагчдын судалгааг регистрийн бүртгэлээр авч IDEA программ ашиглан давхардлыг шалгах, хичээлийн хуваарь, ахлах ангид сонгон суралцах хичээлийн бүлэг дүүргэлт, бүлгийн тоог үндсэн баримттай тулгах
- Боловсролын салбарын санхүүжилтийн талаар олон улсын жишиг судлах
- Тэтгэмж олгохоор төлөвлөсөн багш нарын ажилласан жилийг үндсэн баримтаас нь дахин тооцоолох
- ЕБС, цэцэрлэг, МСҮТ-ийн төлөвлөлтөд хэрэглэх хувьсах зардлын тооцооллыг нормоор давтан шалгах
- Гүнзгийрүүлсэн сургалтын төлбөрийн орлогыг батлагдсан тариф, ангийн хүүхдийн тоогоор дахин тооцоолж шалгах
- Тогтмол зардлын тооцооллыг нийлүүлэгчтэй хийсэн гэрээтэй тулган шалгах
- МСҮТ-ийн хүүхдийн төлөвлөгөөт тоог гүйцэтгэлтэй харьцуулах, тэтгэлэгийн тооцооллыг давтан хийх, холбогдох албан тушаалтан, суралцагчдаас дээрх асуудлаар асууж тодруулах

### **Аудит хийсэн бүрэлдэхүүн**


Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэг, Аудитын менежер Х.Баярмаа нар хянан удирдаж, тус газрын гуравдугаар баг, АНАГ-ын аудитор, шинжээч нар хийж гүйцэтгэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргаав.



## Ерөнхий зүйл

- 1.1 2009-2010 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 814 цэцэрлэгт 142.1 мянга, ерөнхий боловсролын 755 сургуульд 522.1 мянга, мэргэжлийн боловсролын 63 сургуульд 44.7 мянга, дээд боловсролын 146 их, дээд сургууль, коллежид 164.8 мянган оюутан, сурагчид суралцаж байгаа<sup>1</sup> нь Монгол Улсын хүн амын 32.3 хувийг эзэлж байна.
- 1.2 2002 онд батлагдсан “Боловсролын тухай” хууль<sup>2</sup>-д заасны дагуу 2007-2009 онд улсын төсвийн орлогын 18.9 -25.4 хувийг боловсролын санхүүжилтэд зарцуулж иржээ.
- 1.3 Санхүүжилтийн өсөлтийг графикаар үзүүлвэл:



- 1.4 2009 онд улсын төсвийн нийт орлогын 25 хувийг боловсролд зарцуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 18 хувийг зарцуулсан нь өмнөх оныхоос 40.1 тэрбум төгрөгөөр буюу 10.2 хувиар буурсан байна.

## Төлөвлөлтийн эрх зүйн үндэслэл

- 1.5 1995, 2002 онд батлагдсан “Боловсролын тухай” хууль<sup>3</sup> заасны дагуу 2004-2009 онд нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг жил бүрийн 7-8 дугаар сард Засгийн газраас шинэчлэн баталж, ирэх оны төсвийн төлөвлөгөөг зохиож иржээ.
- 1.6 2002 онд шинэчлэн батлагдсан “Боловсролын тухай хууль”<sup>4</sup>-ийн 40.5-д заасны дагуу хувьсах зардлын нормативыг тогтоох аргачлалыг БСШУ-ны сайд шинэчлэн батлаагүй байна.
- 1.7 2006 онд батлагдсан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар<sup>5</sup> ЕБС, цэцэрлэгийн хувьсах зардлыг тогтоож мөрдүүлэх эрхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт олгожээ. Энэ нь Боловсролын тухай хуультай зөрчилдөх тул хуулийн дээрх заалт хэрэгжих боломжгүй байна.

<sup>1</sup> Боловсролын салбарын 2009-2010 оны хичээлийн жилийн статистик мэдээллийн эмхтгэл

<sup>2</sup> 39.1.Боловсролын санхүүжилтэд улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулна.

<sup>3</sup> 40.3.Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно

<sup>4</sup> 40.5.Нэг сурагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан энэ хуулийн 40.3-т заасан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

<sup>5</sup> 30.1.14.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон аргачлалын дагуу ЕБС, цэцэрлэг тус бүрээр нэг сурагчид ногдох хувьсах зардлыг тогтоож мөрдүүлэх

**Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг хувьсах зардлын нормативаар төлөвлөдөг ч Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль болон төсвийн тодотголоор бууруулдаг нь түүнийг ач холбогдолгүй болгож байна**

- 1.8 БСШУЯ 2009 оны төсвийг Засгийн газрын 2008 оны 294 дүгээр тогтоолоор баталсан нормативыг үндэслэн 545.2 тэрбум төгрөгөөр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлжээ. “Монгол Улсын 2009 оны төсвийн тухай” хуулиар БСШУ-ны салбарын төсвийг 485.1 тэрбум төгрөгөөр баталсан нь анх төлөвлөснөөс 60.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- 1.9 “Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус салбарын төсвийг 442.0 тэрбум төгрөг болгож, 43.1 тэрбум төгрөгөөр бууруулсан нь хувьсах зардлын төсөвт нөлөөлж, Засгийн газрын 294 дүгээр тогтоолоор баталсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг мөрдөх боломжгүй болжээ. 2009 оны ЕБС-ийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт 1-ээр харуулав.

Нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг 2007-2009 оноор харьцуулсан судалгаа

(сумын сургуулийнхаар, мянган төгрөг)

	Сургуулийн байршил	ЗГ-ын 2007 оны 184 дүгээр тогтоолоор	ЗГ-ын 2008 оны 294 дүгээр тогтоолоор	ЗГ-ын 2009 оны 190 дүгээр тогтоолоор	2008 2007 %	2009 2008 %	2009 2007 %
	Багийн бага сургууль	222.1	379.7	329.2	70.9	-13.3	48.2
	Бага сургууль		287.7	248.4		-13.6	
Суурь боловсролын сургууль	Бага анги	103.0	200.2	174.7	94.3	-12.7	69.6
	Дунд анги	147.6	306.4	269.3	107.6	-12.1	82.4
Бүрэн дунд сургууль	Бага анги	97.3	181.7	160.5	86.7	-11.7	64.9
	Дунд анги	137.8	262.2	231.8	90.3	-11.6	68.2
	Ахлах анги	144.8	276	244.0	90.6	-11.6	68.5

- 1.10 Засгийн газрын 2007 оны 184 дүгээр тогтоолыг хүчингүй болгож нэг сурагчид ногдох хувьсах зардлын нормативыг 2008 оны 294 дүгээр тогтоолоор шинэчлэн батлахдаа 70.9-107.6 хувиар (0.7-2.1 дахин ) өсгөсөн байна.
- 1.11 Үүнийг 2007-2008 онд улсын төсвийн орлого 17.0 хувиар буурсантай харьцуулахад өндөр өсөлт харагдаж байна.
- 1.12 Засгийн газрын 2009 оны 190 дүгээр тогтоолоор нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын норматив өмнөх оныхоос 11.6-13.6 хувиар буурсан юм. Энэ нь 2007 оныхтой харьцуулахад 48.2-82.4 хувиар өссөн тооцоо гарч байна. 2009 оны улсын төсвийн орлогыг 2007 оныхтой харьцуулахад 19.6 хувиар буурсан дүн гарч байна.
- 1.13 Төсвийг хувьсах зардлын нормативаар төлөвлөсөн ч “Монгол Улсын төсвийн тухай хууль” болон төсвийн тодотголоор үндэслэлгүй бууруулдаг нь сургуулийн удирдлага хүүхдийн тоог зохиомлоор өсгөн төсвөө төлөвлөхөд хүргэж байна.
- 1.14 Боловсролын салбарт хувьсах зардлын нормативаар хөтөлбөрт суурилсан төсвийг төлөвлөж байгаа ч тайлагнал нь түүнтэй уялдахгүй байгаагаас хөтөлбөрийн гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна.
- 1.15 ЕБС-иудаас ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2009-2010 оны хичээлийн жилийн хүүхдийн тоо төлөвлөгөөгөөр 543299 хүүхэд, гүйцэтгэлээр 517823 хүүхэд болж 25476 хүүхдээр дутаж байна. (Хавсралт 2)
- 1.16 Түүнчлэн ЕБС-иудын хүүхдийн нэгдсэн жагсаалтад судалгаа хийхэд регистрийн дугаар давхардсан 23692 хүүхэд, үүнээс овог, нэр, регистрийн дугаар ижил 11327 хүүхэд байна.

- 1.17 Давхардлын шалтгааныг судалж үзвэл сургууль, анги хоорондын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 3798 давхардал байгаа бол илүү төсөв авахын тулд хүүхдийн тоог 7529-өөр өсгөж төлөвлөжээ.
- 1.18 Энэ тоог нийслэлийн сургуулийн хүүхдийн дундаж тоо (1500 хүүхэд)-нд харьцуулвал ойролцоогоор 5 сургуулийн хувьсах зардал 1.7 тэрбум төгрөгийг давхардуулан олгож байна гэж үзэж болохоор байна.
- 1.19 Боловсролын салбарын нэгдсэн мэдээллийн системийг сайжруулах ажлыг сүүлийн хоёр жилд хийж байгаа боловч хяналт тавьж, хариуцлага тооцох механизм хангалтгүйгээс төсвийг нэмж төсөвлөх, үргүй зарцуулах үндэс болж байна.

**Нэг багшид дунджаар 20 хүүхэд ногдож байна**

- 1.20 Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд боловсролын үзүүлэлтүүдийг дараахь түвшинд хүргэхээр төлөвлөжээ. Хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр харуулбал;

	Үзүүлэлт	Хот		Хөдөө	
		2006 он	2010 он	2006 он	2010 он
1	СӨБ, цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	13,0-11,0	24,8	13,0-11,0	24,3
2	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	33,5-27,4	32,6	30,9-24,7	29,1
3	Дунд, ахлах ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	22,5-16,0	14,2	20,9-14,8	14,8

- 1.21 2009-2010 оны хичээлийн жилд ЕБС-иудад 26070, цэцэрлэгт нийт 4465 багш ажиллаж дунджаар 20 сурагч болон 24.5 цэцэрлэгийн хүүхдэд тус тус нэг багш ногдож, дунд ахлах ангид суралцагчдын тоо мастер төлөвлөгөөний хүрэх түвшинг хангаж байна.

- 1.22 Гэвч ЕБС, цэцэрлэгийн багшийн тоог сургууль бүрт харилцан адилгүй төлөвлөсөн байна.

- Нийслэлд 7095 багш шаардлагатай боловч 74 багш дутуу ажиллажээ.
- Дорноговь, Өмнөговь, Булган аймаг багшийн хэрэгцээг 20-42 -оор илүү төлөвлөсөн, Говь-Алтай аймагт 55 багш илүү ажиллажээ.

- 1.23 Батлагдсан журмаар<sup>6</sup> нэг багш долоо хоногт 19 цагийн хичээл заах ёстой ч тухайн сургуулийн бүлгийн тоо, сонгон суралцах хичээл зэргээс хамаарч 16-22 цагийн хичээл заахаар төлөвлөгөө хөтөлбөр зохиогдож байна.

- 1.24 ЕБС-ийн багш нарын орон тоог анги дүүргэлтээс хамаарч тогтоодог бөгөөд нийслэлийн хэмжээнд анги дүүргэлт өндөр, сум, багийн түвшинд хангалтгүй байна. Тухайлбал,

- Төв аймгийн Сэргэлэн сумын дунд сургуулийн нэг бүлэг 2-10, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Бүрэнцогт багийн бага сургуулийнх 9.4-10.2, Баян-Өлгий аймгийн Ногоон нуур сумын Асгат багийн бага сургуулийнх 1-4 хүүхэдтэй,
- Сэлэнгэ аймгийн Жавхлант, Орхонтуул, Номгон зэрэг сум, тосгодын сургуулиуд нийт 25-27 хүүхэдтэй,
- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4 дүгээр сургууль 9 бүлгийн 104 сурагчтай бөгөөд 11 багш шаардлагатай байна.

- 1.25 Анги дүүргэлт заасан хэмжээнд хүрдэггүй нь багш нарын цалингийн сан бага төлөвлөгдөх, мэргэжлийн бус багш нар хичээл заах нөхцөлийг бий болгож, улмаар сургалтыг стандартын дагуу явуулахад сөргөөр нөлөөлж байна.

- 1.26 Улсын төсвөөс нийслэлийн нэг сурагчид 291.8 мянган төгрөгийн зардал гаргасан байхад багийн бага сургуулийн нэг сурагчид зөвхөн багшийн цалин, эрүүл мэнд, нийгмийн

<sup>6</sup> БСШУ, НХХ-ийн болон Сангийн сайдын хамтарсан 307/91/237 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”



даатгалын шимтгэлээр 822.4 мянган төгрөгийн зардал гарсан тооцоо гарч байгаа нь суралцагч цөөтэй багийн бага сургуулийг ажиллуулах нь нийслэлийн сургуулийнхаас өндөр зардалтайг харуулж байна.

- 1.27 Багш нарын үндсэн цалинг Засгийн газрын 2007 оны 351 дүгээр тогтоолоор баталсан “сургуулийн өмнөх боловсролын болон бага дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний багш, ажилчдын цалингийн доод жишиг”-ийг үндэслэн тогтоодог.
- 1.28 Засгийн газрын 2007 оны 237, 351 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн багш болон эмч, эмнэлгийн ажилтны цалингийн сүлжээг шинэчлэн баталснаар үндсэн цалин 28.5-95.0 хувиар нэмэгджээ.
- 1.29 Боловсролын салбарын багш, ажилтнуудын цалингийн сүлжээг шинэчилсэн эрх зүйн актуудыг үзүүлбэл:

Эрх зүйн актын нэр	Дугаар	Үндэслэсэн хуулийн заалт	Баталсан огноо	Мөрдөх огноо
<b>ТАХ-ын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай</b>	ЗГ-ын 2007 оны 13 дугаар тогтоол	ТАТХ-ийн 28.6	2007.01.10	2007.01.01
<b>Түр аргачлал батлах тухай</b>	БСШУ-ны сайдын 2007 оны 308 дугаар тушаал	ТБУСТХ-н 12 дугаар зүйл, НХХ-н сайдын 2007 оны 2/1320, СС-н 2007 оны 3-56/3320	2007.08.31	2007.09.01
<b>ТАХ-ын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай</b>	ЗГ-ын 2007 оны 237 дугаар тогтоол	ТАТХ-ийн 28.4.3, 28.6, 28.8	2007.09.27	2007.10.01
<b>ТАХ-ын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай</b>	ЗГ-ын 2007 оны 351 дүгээр тогтоол	ТАТХ-ийн 28.4.3, 28.6	2007.12.06	2008.01.01

- 1.30 ЕБС-ийн нэг багшийн үндсэн цалин 229.5-269.5 мянга, удирдах албан тушаалтных 277.1-341.0 мянга, үйлчилгээний ажилчдынх 140.2-193.5 мянган төгрөг байна. Нэг багшийн дундаж цалин 286.7 мянган төгрөг байгаа ч сургууль бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал,

- Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуульд 299.3- 559.6 мянган төгрөг байхад Нийслэлийн СХД-ийн 65 дугаар сургуульд 233.1-415.0 мянган төгрөг байна.

- 1.31 ЕБС-ийн багшид анги даасан, кабинет хариуцсан, заах аргын нэгдэл удирдсаны нэмэгдэл хөлсийг 5-10 хувиар<sup>7</sup>, заах аргач, тэргүүлэх, зөвлөх багшийн мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 10-20 хувиар, илүү цаг заасны хөлс<sup>8</sup>, ур чадварын нэмэгдлийн доод хэмжээг 10 хувиар<sup>9</sup>, аймаг, сумын ЕБС, цэцэрлэгийн ажилтнуудад олгох нэмэгдлийг аймгийн төвд 8-10, суманд 10-15 хувиар<sup>10</sup> тус тус үндсэн цалингаас тооцон олгож байна.
- 1.32 БСШУ-ны сайдын 2007 оны 354 дүгээр тушаалаар<sup>11</sup> дэвтэр засах, сонгоны хичээл заах, шүүлэг, шалгалт авах нь багшийн ажлын байрны үндсэн зорилтод хамаарах тул тэдгээрт тусгайлсан нэмэгдэл хөлс тооцох үндэслэлгүй болсон байна.

<sup>7</sup> Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоол “Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай”

<sup>8</sup> БСШУ, НХХ-ийн болон Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаал “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам

<sup>9</sup> ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”

<sup>10</sup> ЗГ-ын 2001 оны 90 дүгээр тогтоол “Аймаг сумын ЕБС, цэцэрлэг соёлын төвийн ажилтнуудад олгох цалингийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоох тухай”

<sup>11</sup> “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт”

- 1.33 ЕБС болон цэцэрлэгийн удирдлага цалин болон нэмэгдэл хөлсийг буруу тооцож олгосон зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

*Говь-Алтай аймагт ЗГ-ын 2007 оны 219 дүгээр тогтоол, БСШУЯ-ны сайдын 2008 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчиж 9 сургуулийн захиралд 4.7 сая, Төв аймагт 13 сургуулийн захиралд 10.8 сая төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон;*

*Өвөрхангай аймгийн Төгрөг сумын сургуулийн захирал 2009 онд багш нарын цалинг ЗГ-ын 2007 оны 354 дүгээр тогтоолд заасан жишгээр ангиллыг буруу тогтоосноор 3.1 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.*

- 1.34 БСШУ-ны сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлсэн 1<sup>а</sup>/1744 дүгээр албан бичигт Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор олгодог ур чадварын нэмэгдлийг олгохгүй байх нь зүйтэй гэсэн бол, 2009 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 1<sup>а</sup>/2198 дугаар албан бичгээр “УИХ-ын 27 дугаар тогтоолыг хэрэгжүүлж цалин, нэмэгдэл, урамшууллыг бууруулахгүйгээр зохион байгуулахыг зөвшөөрсөн ч зарим сургууль 2009 оны 5 дугаар сараас ур чадварын нэмэгдлийг зогсоосон байна.

**Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийг урсгал зардалд зарцуулжээ**

- 1.35 “Боловсролын тухай хуульд<sup>12</sup>” заасны дагуу 2009 онд өндөр насны тэтгэвэрт гарах багшид олгох тэтгэмжид салбарын хэмжээгээр 3873.2 сая төгрөг баталж 3478.4 сая төгрөг зарцуулсан байна.
- 1.36 Сургууль цэцэрлэгийн хувьсах зардлыг төлөвлөсөн хэмжээнд олгоогүйгээс дээрх хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарах багшид олгох тэтгэмжийг илүү төлөвлөн үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Тухайлбал,

*Хөвсгөл аймагт өндөр насны тэтгэвэрт гарахад олгохоор батлуулсан төсвийг үйл ажиллагааны зардалд, Говь-Алтай аймагт 85.6 сая төгрөгийн тэтгэмж олгохоор төлөвлөж, 73.3 сая төгрөгийн тэтгэмж олгож, 7.7 сая төгрөгийг өөр зардалд, Сүхбаатар аймагт 11 сургууль, цэцэрлэгийн 17 багшид 78.9 сая төгрөг олгохоор төсөвлөж 2 цэцэрлэгийн эрхлэгч тэтгэвэртээ гараагүйгээс хэмнэгдсэн 18.6 сая төгрөгийг усны өр, бусад бараа ажил үйлчилгээний зардалд, Говьсүмбэр аймагт 8 хүнд 36.0 сая төгрөг олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 5 хүнд 20.3 сая төгрөгийн тэтгэмжийг олгож, 15.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа тус тус зарцуулсан;*

*Өмнөговь аймагт ЕБС-ийн 13 багшид 59.4 сая төгрөг олгохоор төлөвлөж, нийт 12 хүнд 48.8 сая төгрөг олгож, 1 цэцэрлэгийн багшийн ажилласан жил дутуу тул олгоогүй байна.*

- 1.37 Төрийн албаны тухай хуульд сургуулийн захирлыг төрийн захиргааны албан хаагчийн ангилалд оруулах өөрчлөлт хийгдэх юм гэсэн сургаар тэтгэмжийг 36 сараар төлөвлөж, заримыг нь олгосон байна. Тухайлбал,

*Баянхонгор аймгийн Шинэжинст сумын сургуулийн захирал н.Ёндон, Баянхонгор сумын цэцэрлэгийн эрхлэгч н.Цээрэгзэн нарт 36 сараар тооцож 24.2 сая төгрөг олгосон ч ажлаа хийсээр байгаа;*

*Дархан-Уул аймагт 2 захирлын тэтгэмжийг 36 сараар олгосонтой холбоотойгоор 10.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;*

*Ховд аймагт 2 захирлын тэтгэмжийг 36 сараар төлөвлөсөн, 2 багш тэтгэвэртээ гараагүйгээс 21.4 сая төгрөг үлдэж, урсгал зардалд зарцуулсан;*

*Төв аймгийн Сүмбэр сумын 1 багшид 36 сарын 12.1 сая төгрөгийн тэтгэмжийг олгохоор төлөвлөсөн байна.*

<sup>12</sup> 43.1.4.бүх шатны сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоологдох бол 12 сарын, үүнээс сум тосгон,багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол 18 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгох

**Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарт олгох тэтгэмжийн төсвийг батлуулаагүйгээс Үдийн цайны болон тогтмол зардлаас нөхжээ**

- 1.38 “Боловсролын тухай хуульд<sup>13</sup>” заасны дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид салбарын хэмжээгээр 1631.9 сая төгрөг зарцуулахаар баталж 1594.9 сая төгрөг зарцуулжээ.
- 1.39 Уг тэтгэмжийг үндэслэлгүй төлөвлөж илүү санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах, шалгуур хангаагүй багш, ажилтнуудад олгох, өөр зардлаас санхүүжүүлэх зөрчил нилээд байна. Тухайлбал;

*Увс аймагт хугацаа болоогүй 7 багшид 8.3 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламжид 0.4 сая төгрөг олгосон ;*

*Хөвсгөл аймагт төсөвлөөгүй 8.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжаар Үдийн цай хөтөлбөрөөс олгосны дотор хугацаа болоогүй 3 багшид 4.1 сая төгрөг олгосон;*

*Хэнтий аймагт 2008 онд 3 багшийн нэр дээр 4.2 сая төгрөгийн төсөв батлуулан авч МХГ-ын акт барагдуулах болон урсгал зардалд зарцуулж 2009 онд Үдийн цайны болон тогтмол зардлаас нөхөж олгосон;*

*Завхан аймагт төсвийн тодотголоор 5.5 сая төгрөг илүү хуваарилсныг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан;*

*Орхон аймагт ажилласан жил дутуу 9 багшид 8.3 сая төгрөг, 2 багшид 1.5 сая төгрөг давхардуулан, 1 багшид 0.2 сая төгрөгийг дутуу олгосон;*

*Баян-Өлгий аймгийн Алтанцэгц сумын ахлах сургуулийн төсөвт 1 багшид тэтгэмж олгохоор тусгасан ч 2 багшид тэтгэмж олгож, нэг багшийн тэтгэмжийг дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс олгосон;*

*Төлөвлөлтийн буруугаас Сүхбаатар аймаг 4.3 сая, Төв аймаг 11.9 сая, Булган аймаг 1.4 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсвийг хэтрүүлсэн;*

*Дархан-Уул аймагт 2 багшийн ажилласан жил, цалинг илүү, Өмнөговь аймагт 4 багшид 5.7 сая төгрөгийн тэтгэлгийг буруу тооцож төлөвлөсөн байна.*

- 1.40 Боловсролын тухай хуулийн 43.1.7-д “сум..-ын сургууль” гэж зааснаас аймгийн төвийн сумдад ажиллаж байгаа цэцэрлэг, ЕБС-ийн багш нарт олгогдож хөдөөгийн сум, тосгон, багийн сургуульд багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах хөшүүрэг болж чадахгүй байна.

**Үр дүнгийн урамшууллыг зориулалт бусаар зарцуулсан байна**

- 1.41 Засгийн газрын 2008 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох” журмын дагуу БСШУ-ны болон Сангийн сайдын 2009 оны 97/169, 197/347, 278/561 дүгээр тушаалуудаар ЕБС-ийн болон хүүхдийн цэцэрлэгийн багш ажиллагсад олгох үр дүнгийн урамшуулалд Сангийн сайдын 2009 оны төсвийн багцаас 14311.0 сая төгрөг олгосон байна.
- 1.42 Үр дүнгийн урамшууллын зарцуулагдаагүй үлдэгдлийг буцааж төвлөрүүлэх ёстой ч Баян-Өлгий аймаг 36.4 сая төгрөг, Орхон аймаг 9.4 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй зориулалт бусаар зарцуулжээ.

<sup>13</sup> 43.1.7.сум тосгон,багийн сургууль цэцэрлэгийн багшид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох,

**Гүнзгийрүүлсэн сургалт явуулах төлбөрийн хэмжээгээр төсвөөс олгох санхүүжилтийг бууруулсан нь Боловсролын тухай хуулийг зөрчсөн байна**

- 1.43 2009 онд Сангийн яам ЕБС-ийн төсвийн тодотголыг батлахдаа гүнзгийрүүлсэн сургалтын төлбөрийн орлогын хэмжээгээр түүнийг олохтой холбогдон гарах зардлыг батлаагүйгээр төсвөөс авах санхүүжилт 2.9 тэрбум төгрөгөөр буурч Боловсролын тухай хуулийг<sup>14</sup> зөрчсөн байна.
- 1.44 Энэ нь БСШУ-ны сайдын 2002 оны 333 дугаар тушаалыг<sup>15</sup> хэрэгжүүлэх боломжгүй болгож, орлогоо дутуу төлөвлөх, арилжааны банкинд данс нээлгэх, бүртгэлээс гадуур зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

*Нийслэлд 1526.0 сая, Ховд аймагт 29.8 сая, Өвөрхангай аймагт 32.1 сая, Хэнтий аймагт 2.9 сая төгрөгөөр орлогоо дутуу төлөвлөсөн;*

*Хөвсгөл аймагт 35.8 сая, Төв аймагт 15.0 сая, Дорноговь 8.7 сая төгрөгийн орлогыг төлөвлөөгүй;*

*Увс аймагт 16.0 сая, Сүхбаатар аймагт 6.1 сая, Говьсүмбэр аймагт 2.4 сая төгрөгийг арилжааны банкинд төвлөрүүлж, түүгээрээ зарцуулсан;*

*Өвөрхангай аймагт 17.6 сая, Төв аймагт 15.0 сая төгрөгийг бүртгэлээс гадуур зарцуулсан байна.*

- 1.45 Боловсролын салбарт 2010 онд дээрх журмын дагуу 4.0 тэрбум төгрөгийн орлого, зарлагыг төлөвлөж батлуулсан байна.

**Засаг даргын захирамжаар боловсролын төсвөөс санхүүжүүлж гадаадад явуулжээ**

- 1.46 УИХ-ын 2009 оны 27 дугаар тогтоолоор “төсвийн бүх шатны байгууллагуудад төсвийн зардлын хэмнэлтийн хатуу зарчмыг баримталж, зардлыг бууруулахыг даалгаж”, тэвчиж болох зардлын зүйлд гадаад томилолтын зардлыг нэрлэжээ.
- 1.47 Гэтэл нийслэлийн зарим сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, багш зэрэг 192 хүнийг дүүргийн Засаг даргын захирамжаар гадаад оронд богино хугацааны сургалт, семинар, тойрон аялалд оролцуулж 110.1 сая төгрөгийг боловсролын төсвөөс санхүүжүүлсэн байна.

**Боловсролын газар төсвийн хуваарийг удаа дараа өөрчилсөн байна**

- 1.48 Аймаг, нийслэл, дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсүүд төсөвт байгууллагуудад санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг олгохдоо Сангийн сайдын баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ыг мөрдөх ёстой.
- 1.49 Дээрх журамд Санхүү, төрийн сангийн хэлтсээс санхүүжилтийн эрхийг олгохдоо төсвийн сар, улирлын хуваарийг 2009 онд Боловсрол соёлын газраас баталж ирүүлснээр, 2010 оны 3 сараас эхлэн тухайн шатны Засаг даргын баталсны дагуу хийхээр заажээ.
- 1.50 Зайлшгүй тохиодолд батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахдаа зөвхөн *байгууллага дотор* нь зардлын зүйл хооронд гүйлгэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс шийдэх, харин төсвийн багцын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч байгууллага

<sup>14</sup> 39.4. “Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно”

<sup>15</sup> 3.9. “Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтын нэмэгдэл зардлыг сургалтын орчныг сайжруулах, гарын авлага, сургалтын бусад хэрэглэгдэхүүнээр хангах, тухайн хичээлийг зааж байгаа багш, хичээлийн туслах ажилтанд нэмэгдэл хөлс олгоход зарцуулна. Багш, туслах ажилтанд олгох нэмэгдэл хөлсний хэмжээ нь тухайн сургалтын зардлын 30 хувиас хэтрэхгүй байна”

хооронд зохицуулалт хийх тухай саналаа Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэхээр заасан байна.

- 1.51 Гэтэл Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсвийн 2010 оны сар, улирлын хуваарийг баталгаажуулахдаа дүүрэг хооронд гүйлгэн хуваарилсан нь дээрх журмыг зөрчсөн байна.

Нийслэлийн ЕБС-ийн 2010 оны төсвийн хувиарлалтыг харьцуулсан судалгаа

(Сая төгрөгөөр)

№	Дүүрэг	Нийслэлийн боловсролын газрын хуваарь (Төсвөөс санхүүжих)	Нийслэлийн төрийн сангаас хийсэн хуваарь		Өөрчлөлт /+илүү, (-) дутуу/	
			2010.01.20	2010.06.06	2010.01.20-ныхоор	2010.06.06-ныхаар
1	БГД	9061,3	9129,0	9177,9	67,7	116,6
2	БНД	1953,3	1953,3	1953,3	0,0	0,0
3	БХД	415,3	415,3	415,3	0,0	0,0
4	БЗД	11425,7	11425,7	11414,4	0,0	(11,3)
5	НД	2632,3	2564,6	2564,6	(67,7)	(67,7)
6	СХД	10095,4	10095,4	10095,4	0,0	0,0
7	СБД	7466,0	7401,0	7363,3	(65,0)	(102,6)
8	ХУД	5591,1	5656,1	5656,1	65,0	65,0
9	ЧД	6375,7	6375,7	6375,7	0,0	0,0
	<b>ДҮН</b>	<b>55016,1</b>	<b>55016,1</b>	<b>55016,1</b>	<b>0,0</b>	<b>(0,0)</b>

- 1.52 2009 онд нийслэлийн СХД-ийн хувийн хэвшлийн 12 цэцэрлэгт 117.5 сая төгрөг төрийн өмчийн цэцэрлэгийн төсвөөс, Баянгол дүүргийн хувийн хэвшлийн 14 сургуульд 127.1 сая төгрөгийг халаалтын зардлаас, Говьсүмбэр аймагт хувийн цэцэрлэгт хоол, тогтмол зардалд 9.0 сая төгрөгийг олгосны дээр Баянгол дүүрэг 2010 онд 107.7 сая төгрөгийг хувийн сургуулийн дулаанд, хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн цэвэр, бохир усны зардалд 15.5 сая төгрөг олгохоор төсөвлөсөн нь ТБУСТХ-ийн 12.1.1-д<sup>16</sup>, Боловсролын тухай хуулийн 40.2-т<sup>17</sup>-т заасныг зөрчсөн байна.

- 1.53 Боловсролын газар ч төсвийн хуваарийг бодитой хийж ирүүлээгүй байна. Тухайлбал, нийслэлд 2010 оны төсвийн хуваарийг эхний хагас жилд 3 удаа өөрчлөөд байна. Мөн 2009 оны жилийн эцсээр нийслэлийн ЕБС, цэцэрлэгийн санхүүжилт дутагдаж БСШУЯ-наас зохицуулалт хийж 1.7 тэрбум төгрөгийг олгосон, Сэлэнгэ аймагт БСГ-ын хийсэн төсвийн тодотгол бодит байдлаас ихээхэн зөрж ЕБС-ийн төсвөөс 77.9 сая төгрөг хасч, боловсрол, соёл, шинжлэх ухааны бусад байгууллагад нэмж зарцуулсан, Төв аймагт цалингийн зардал 117.7 сая төгрөгөөр дутагдаж 10 дугаар сард тодотгол хийсэн байна.

- 1.54 Засгийн газрын 2009 оны 190 дүгээр тогтоолоор хувьсах зардлын норматив буурч батлагдсан нь 2010 онд тус салбарт төсөв дутагдахад зарим талаар нөлөөлжээ. Тухайлбал, Нийслэлийн ЕБС-ийн зөвхөн үндсэн ажиллагсадын цалингийн зардлыг авч үзэхэд 2009 оны аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 38831.1 сая төгрөг гарсан бол 2010 онд 37193.3 сая төгрөгийн төсөв баталжээ.

- 1.55 Нийслэл, зарим дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс байгууллагуудад хүргүүлж байгаа төсвийн хуваарийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй нь Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмыг<sup>18</sup> зөрчсөн байна.

### **ЕБС-ийн дотуур байрны хоолны зардлын норматив, шаардагдах илчлэгийн хэмжээ уялдаа муутай байна**

- 1.56 2009 онд улсын төсвөөс дотуур байрны хоолны зардалд 8864.2 сая төгрөг төсвийн тодотголоор баталж 8194.9 сая төгрөг зарцуулж, 669.3 сая төгрөг хэмнэсэн байна.

<sup>16</sup> “эрхлэх асуудлынхаа хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого, санхүүжилтийн хэрэгцээгээ бодитой тодорхойлох”, 13.2-т

“улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”,

<sup>17</sup> Төрийн өмчит бүх шатны сургуулийн тогтмол зардлыг ...улсын төсвөөс санхүүжүүлнэ”

<sup>18</sup> 3.2 “...орон нутгийн төрийн сан тухайн орон нутгийн ИТХ-аар болон орон нутгийн боловсрол соёлын газар болон эрүүл мэндийн газраас баталж ирүүлсэн сар, улирлын төсвийн хуваарийг үндэслэн тухайн сар, улирлын санхүүжилтийн эрхийн тооцоог хийж, тайлант үеийн эхэнд нэг удаа ЗЭБ-1 маягтын дагуу баталгаажуулан олгоно.”



- 1.57 “Хоолны дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2008 оны 45 дугаар тогтоолоор ЕБС-ийн болон МСҮТ-ийн дотуур байрны хүүхдийн хоногийн хоолны зардлыг 868 төгрөгөөр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг өдрийн цэцэрлэгт 329 төгрөг, 24 цагийн цэцэрлэгт хоногт 493 төгрөгөөр тус тус баталсан байна.
- 1.58 2008 онд батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-д<sup>19</sup> зааснаар хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, Засгийн газрын 2009 оны 85 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг өдрийн цэцэрлэгт 1100 төгрөг, 24 цагийн ажиллагаатай цэцэрлэгт 1600 төгрөг байхаар баталснаар ЕБС-ийн дотуур байрны хоолны норм хэвээр үлдсэн байна.
- 1.59 Цэцэрлэгийн хүүхдийн хоолонд нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг АХБ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын үйлчилгээг дэмжих” төслөөс нөхөх арга хэмжээ авахыг Сангийн сайдад даалгаснаар 2009 онд 1542.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.
- 1.60 Хүүхдийн хоолны хоногийн норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээгээр тооцоход 1-5 настай хүүхдийн өдөрт шаардагдах илчлэг нь 1569.2-1770.1 илчлэгтэй хоол хэрэглэж өдөрт 1100-1600 төгрөг зарцуулдаг байхад, ЕБС, МСҮТ-ийн 6 -19 настай хүүхэд 2151.1-2662.2 ккал буюу цэцэрлэгийн хүүхдээс 37.1-50.4 хувиар илүү илчлэгтэй хоол хэрэглэх ёстой ч өдөрт 868 төгрөг байгаа нь 232-732 төгрөгөөр буюу 21.0-45.8 хувиар бага байна.
- 1.61 Дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, хүрэлцээг хангах зорилгоор хүүхдийн тоог өсгөж төлөвлөх, нэг хүүхдэд ногдох хоолны зардал төлөвлөгөөнөөс хэтрэх зөрчил гарсан байна. Тухайлбал, Хэнтий аймагт 41.9 сая, Төв аймагт 57.6 сая төгрөг, Говьсүмбэр аймагт 5.5 сая төгрөг, Орхон аймагт 4.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь нэг хүүхдэд ногдох зардал 868 төгрөгөөс давсантай холбоотой байна.
- 1.62 БСШУЯ-наас 2009 онд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх чиглэлээр гадны эх үүсвэр эрэлхийлж, хямралын эсрэг Боловсролын хөтөлбөрийг боловсруулж, ЗГ-аар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барьсан боловч шийдэгдээгүй байна.

***Хүүхдийн тоог өсгөж төлөвлөснөөс хоолны зардлын хэмнэлт гарч бусад зардалд шилжүүлэн зарцуулжээ***

- 1.63 Хүүхдийн тоог Говь-Алтай аймагт 505-аар, Дундговь аймагт 294-өөр, Хөвсгөл аймагт 279-өөр, Өвөрхангай аймагт 202-оор, Баянхонгор аймагт 176-гаар, Увс аймагт 104-өөр тус тус өсгөж төлөвлөснөөс 14.8-151.6 сая төгрөгийн хоолны зардлын хэмнэлт үүсч өөр зардлын эх үүсвэрт ашигласан байна.

***Тогтмол зардлыг бодитой төлөвлөөгүй байна***

- 1.64 2009 оны эцэст үүссэн 2.0 тэрбум төгрөгийн өр нь шинээр баригдсан өргөтгөлийн барилгын тогтмол зардлыг дутуу тооцсон, хасч баталсан, тодотголоор бууруулсан, тогтмол зардлын үнэ өссөн, засварын ажил хийхтэй холбогдон гарах гэрэл, цахилгааны зардлыг төсөвт тусгаагүй зэргээс шалтгаалжээ.
- 1.65 2009 онд нийслэлд тогтмол зардалд 8778.9 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 8670.1 сая төгрөг зарцуулж, 108.7 сая төгрөг үлдсэн боловч СБД, ЧД-т төсөв хэтэрсэн, БГД 73.5 сая төгрөгийн үлдэгдлийг тогтмол зардалд шилжүүлэн авлагаар бүртгэсэн байна.

<sup>19</sup> 15.1.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, ном, гарын авлага болон хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тоглоомоор хангах зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Гэрэл, цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны төлөвлөгөө гүйцэтгэл дүүргээр сая/төг									
Дүүрэг	Гэрэл цахилгаан		Түлш халаалт		Цэвэр бохир ус		нийт дүн		зөрүү
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	
БНД	32.7	31.9	264.2	244.3	59.5	54.8	356.4	331	25.4
БХД	15.7	10.5	92.2	93.8	7.4	5.4	115.3	109.7	5.6
БГД	166.7	158.5	935	977	295.6	261.6	1397.3	1397.1	0.2
БЗД	134.2	175.6	930.2	897.5	257.1	235.6	1321.5	1308.7	12.8
НД	93.6	98.3	713.6	581.7	109.5	123.6	916.7	803.6	113.1
СБД	127.4	129.3	732	795.1	216.9	204.5	1076.3	1128.9	-52.6
СХД	149.7	160.7	1,085.40	1,058.80	464	410.5	1699.1	1630	69.1
ХУД	113.8	108	645.7	655.4	160.8	128.3	920.3	891.7	28.6
ЧД	120.3	139.1	648.7	692.4	198.3	179.2	967.3	1010.7	-43.4
УБ	2.2	16.9	4.1	36.5	2.5	5.5	8.8	58.9	-50.1
Нийт дүн	<b>956.2</b>	<b>1,029.0</b>	<b>6,051.0</b>	<b>6,032.4</b>	<b>1,771.7</b>	<b>1,608.8</b>	<b>8778.9</b>	<b>8670.2</b>	<b>108.7</b>

- 1.66 Шинээр ашиглалтад орох объектын зардлын төсвийг батлаагүй, төсвийн тодотголоор үндэслэлгүй бууруулсан нь тогтмол зардлын хэтрэлтэд зарим талаар нөлөөлсөн байна. Тухайлбал,

*Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 100 хүүхдийн цэцэрлэг барьж, Тариат, Чулуут сумын хичээлийн байрны өргөтгөл хийсэнтэй холбоотой зардлын эх үүсвэр батлаагүйгээс хөрөнгийн үүсвэр дутагдсан,*

*Хөвсгөл аймагт шинээр ашиглалтад орох барилгын тогтмол зардлыг тооцон төлөвлөсөн боловч хасагдсанаас 86.0 сая төгрөгийн хэтрэлт үүссэн.*

*Баян-Өлгий аймагт ЕБС-ийн тогтмол зардлыг 90.9 сая төгрөгөөр бууруулж баталснаас төсөв дутаж, үдийн цайны хэмнэлтээс шилжүүлэн зарцуулсан,*

*Төв аймагт тогтмол зардлыг төсвийн тодотголоор бууруулж баталснаас 336.4 сая төгрөгөөр хэтэрч, дахин тодотгол хийж 175.6 сая, БСШУЯ-наас 142.1 сая төгрөг нэмж өгсөн ч 18.7 сая төгрөг дутаж өөр зардлаас нөхсөн байна.*

- 1.67 Тогтмол зардлыг хичээлийн байрны тоо, дулаан, цахилгаан, ундны болон хэрэглээний усны эх үүсвэрийн ялгааг харгалзаж төлөвлөөгүй, төсвийн тодотголоор үндэслэлгүй бууруулсан байна.

### **Тогтмол зардлын үнийн өсөлт төсөв хэтрэх нөхцөл үүсгэж байна**

- 1.68 Эрчим хүчний зохицуулах Зөвлөлийн хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс Улаанбаатар хотын хэрэглэгчдийн цахилгааны үнийг дунджаар 17.4 хувь, дулааны үнийг дунджаар 14.5 хувь нэмснээр 2010 оны эхний 5 сарын байдлаар нийслэлийн зарим сургууль 2.0-3.0 сая төгрөгийн өртэй байна. Түүнчлэн,

*Ховд аймагт 2008 оны дундуур хийгдсэн дулааны үнийн өсөлтөөс шалтгаалж үүссэн 32.6 сая төгрөгийн дулааны үнийн өрийг 2009 оны төсвийн хэмнэлтээс төлсөн байна.*

*Булган аймагт 2009 оны 8 дугаар сард дулааны, 10 дугаар сард усны үнэ өссөнөөр БСШУЯ-ны төвлөрсөн арга хэмжээнээс 96.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авчээ.*

- 1.69 Аймгууд ЕБС-ийн тогтмол зардлыг өндөр төлөвлөж хэмнэлт гарган, хөрөнгө бэлтгэх, өр барагдуулахад зарцуулсан байна. Тухайлбал,

*Говь-Алтай аймагт 65.4 сая, Говьсүмбэр аймагт 47.9 сая, Баянхонгор аймагт 40.4 сая, Дорноговь аймагт 33.3 сая, Хэнтий аймагт 31.0 сая, Увс аймагт 17.7 сая төгрөг үлдэж зориулалт бусаар зарцуулсан байна.*

*Говь-Алтай аймаг 32.5 сая төгрөгийн тээврийн зардлыг тогтмол зардалд оруулан төлөвлөсөн байна.*

*Булган аймагт БСШУЯ-наас дулааны үнийн зөрүүг илүү авч 2.3 сая төгрөг зориулалт бусаар зарцуулсан байна. Өвөрхангай аймагт шинээр ашиглалтад орох Арвайхээр сумын Сургууль цэцэрлэгийн цогцолборын халаалтын төсөв зарцуулагдаагүйгээс 54.8 сая төгрөг үлдсэн байна.*

- 1.70 Тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй нь төлөвлөлтөд тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

***Сургуулиудын сурах орчин муу, хичээлийн байрны багтаамж хүрэлцээгүй байна***

- 1.71 Нийслэлд 279 хичээлийн байр байгаагийн 14 нь 1953-1959 онд баригдсан, 12 нь 1959-1969 онд баригдсан байна. Үүнээс 50 хичээлийн байр буюу 17.9 хувь нь стандартын шаардлага хангахгүй болжээ.
- 1.72 Нийслэлийн сургуулиудыг суудлаар тооцвол 136.7 мянган хүүхэд сургах хүчин чадалтай боловч 181.0 мянган хүүхэд сурч 44.3 мянган хүүхдээр илүү бөгөөд 2-3 ээлжээр хичээллэж байна.
- 1.73 Нийслэлийн төрийн өмчийн сургуулиудын 10 нь спорт заалгүй байгаа ба шинээр ашиглалтад орсон СБД-ийн 71, СХД-ийн 104, 106-р сургуулиуд спортын болон урлагийн заалгүй баригдсан байна. Түүнчлэн БГД-ийн 70, Оюуны Ундраа цогцолборын 22 дугаар сургуулийн хичээлийн байр, БЗД-ийн 14, СХД-ийн 12 дугаар сургуулийн спорт заал ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн МХГ-ын дүгнэлт гарчээ.
- 1.74 Нийслэлд шинээр баригдах сургууль, цэцэрлэгийн газар олголт удааширдгаас 2009 оны хөрөнгө оруулалтаар баригдсан 4 цэцэрлэг хугацаандаа ашиглалтад ороогүй байна.
- 1.75 Говьсүмбэр аймгийн 1 дүгээр сургууль 640 хүүхдийн хүчин чадалтай ч 1319 хүүхэд суралцаж, анги, танхим хүрэлцээгүй болж сургуулийн стандарт барилгыг өөрчлөн засварлаж бүлгийн тоогоо нэмсэн, соёл, урлагийн заалгүй атлаа Хүүхдийн төлөө хэлтсийг байрлуулжээ.
- 1.76 Гэтэл аймгийн 2 дугаар сургууль хичээлийн 3 байртай, нэг ээлжээр хичээллэн анги танхим хүрэлцээтэй, хүүхэд нэмж авах нөөц бололцоотой байна. Өөрөөр хэлбэл аймгийн төвийн нэг сургууль хэт ачаалалтай, нөгөө нь хүчин чадалдаа хүрч ажиллахгүй байгаад аймгийн БСГ-аас анхаарч ачааллыг тэнцүүлэх, сурагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын байраар хангах шаардлагатай байна.

***Боловсролын салбарын санхүүгийн дотоод хяналт үр нөлөөгүй байна***

- 1.77 Боловсролын салбарын дотоод хяналтыг БСШУЯ, МХГ, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, аймгийн хэмжээнд Мэргэжлийн хяналтын газрын боловсролын хяналтын байцаагч хэрэгжүүлж байгаа ч үр нөлөө хангалтгүй байна.
- 1.78 Тухайлбал, 2009 оны 4 дүгээр сард БСШУЯ, Нийслэлийн боловсролын газар, дүүргүүдийн боловсролын хэлтсийн ажилтнууд нийслэлийн хувийн хэвшлийн 106 сургууль, 80 цэцэрлэгт статистик мэдээний үнэн бодит байдал, хувьсах зардалд нэгдсэн шалгалт хийсэн байна. Шалгалтаар сургуулиудын гаргасан статистик мэдээг журналын бүртгэлтэй харьцуулахад сургууль, цэцэрлэгийн хүүхдийн тоо зөрүүтэй, хувийн хэрэг, түүний хөтлөлт дутуу, сургалтын орчин хангалтгүй гэж дүгнэсэн боловч шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг эргэж тооцсон, арга хэмжээ авсныг нотлох баримт алга байна.
- 1.79 Аудитаар аймаг нийслэл, дүүргийн ЕБС болон МСҮТ-үүдэд нийт 172 төрлийн 402.9 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах акт, 41 төрлийн 334.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 29 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлсэн байна.
- 1.80 Дээр дурьдсан зөрчил нь Боловсролын салбарт дотоод хяналт сулаас хүүхдийн тоог өсгөж төлөвлөн, олгосон санхүүжилтийг үр ашиггүй зарцуулах, Боловсролын тухай хуульд заасан тэтгэмж, тэтгэлгийг зохих журмын дагуу олгохгүй байх зэргээс шалтгаалсан байна.

## **Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулаагүй байна**


- 2.1 Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д заасан “ур чадвар сайтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх”, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн зорилт болгон дэвшүүлсэн “ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мах, сүү, гурил, төмс хүнсний ногоогоор иргэдийг бүрэн хангах”-д шаардагдах мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд НХХЯ болон БСШУЯ бодлогоо чиглүүлж, хамтран ажиллах ёстой юм.
- 2.2 “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль анх 2002 онд батлагдаж, 2009 онд шинэчлэн батлагдсан бөгөөд яамдын хуулиар хүлээсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаархи үүргийг нэгтгэн харуулбал,

Хуулийн нэр	НХХЯ-ны үүрэг	БСШУЯ-ны үүрэг
“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” 2002 оны хуулиар	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, энэ тухай мэдээллээр байгууллага, иргэнийг хангах, мэргэжлийн сургалтын мэдээллийн сан бүрдүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх	Мэргэжлийн боловсролын болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх
“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” 2009 оны хуулиар	Хуулиар тогтоосон эрхлэх асуудлын чиглэлээр Үндэсний Зөвлөлийг бодлогоор дэмжих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын үүрэг: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
“Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2009 оны 1 дүгээр тогтоол	Хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог иж бүрнээр хөгжүүлж, ажилтан, ажилчдыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагажуулах тогтолцоог бий болгоно.	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж, эрэлт нийлүүлэлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна.

- 2.3 Дээрх яамд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хамтарч ажиллавал хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зохистой харьцаа тогтож болохоор байна.
- 2.4 2009 онд батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2009 оны 257 дугаар тогтоолоор БСШУ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Мэргэжлийн боловсрол, сургалтын газар”-ыг байгуулах шийдвэр гарч, 2010 оны 3 дугаар сард тус агентлаг байгуулагдсан ч ажил нь жигдрээгүй байна.
- 2.5 Хуульд зааснаар мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангах, “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолоор, дүрмийг 241 дүгээр тогтоолоор тус тус баталсан байна.
- 2.6 Үндэсний зөвлөл нь салбар бүрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг судлах, тодорхойлох үүрэгтэй салбар зөвлөлүүдтэй байх бөгөөд тэдгээр нь байгуулагдаж эхлээд байна.

**Хувьсах зардлын нормативыг мэргэжлийн чиглэлээр тогтоогоогүй нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцаа алдагдахад нөлөөлж байна**

2.7 МСҮТ-ийн хувьсах зардлын нормативыг Засгийн газраас батлахдаа мэргэжлийн чиглэлийг харгалзан ялгавартай тогтоохоор хуульчилсан ч хэрэгжүүлээгүй, зөвхөн байршлаас хамааруулж ялгавартай тогтоож ирсэн бөгөөд төрийн зохицуулалт хангалтгүйгээс бэлтгэж буй мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээний зохистой харьцаа бий болоогүй байна.



2.8 2009-2010 оны хичээлийн жилд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 63 төв сургалт явуулж байгаагийн дотор авто замын барилгын чиглэлийн мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургууль байхгүй, зөвхөн авто замын засвар, ашиглалтын мэргэжлээр Техник технологийн коллежид 121, Дорнодын МСҮТ-д 26 хүүхэд сурч байгаа нь улсын хэмжээний 44.7 мянга суралцагчдын 0.32 хувийг эзэлж байна. Түүнчлэн ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн мэргэжилтнээр дөнгөж 229 хүүхэд сурч байгаа нь “Ойн тухай” хуулийн дагуу ойн санг нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх үйл ажиллагаа, эрх үүргийг хэрэгжүүлэхэд хангалтгүй байна.

2.9 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлийн ажилчдыг бэлтгэх сургууль цөөн байхад 5270 хүүхэд компьютер, албан хэргийн ажилтан, нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, орчуулагчийн мэргэжлээр сурч байгаа нь МСҮТ-ийн нийт суралцагчдын 11.8 хувийг эзэлж байна. Тухайлбал, Улаангом МСҮТ-д 110, Архангайн “Булган” МСҮТ-д 116 компьютер бичиг хэргийн ажилтан улсын зардлаар бэлтгэгдэж байгаа нь суралцагчдынх нь 6.5-22.0 хувийг эзэлж байна.

Мэргэжлийн төрөл	Тоо	Хувь
Автомашин, машин механизмын жолооч, ашиглалт, засвар үйлчилгээ	5152	11.5
Барилгын төрөл бүрийн мэргэжил	15726	35.2
Компьютер, бичиг хэрэг, нбб-ийн ажилтан	5270	11.8
Хүнсний үйлдвэрлэлийн ажилтан	6860	15.3
Фермер, ХАА-н жолооч, ажилтан	2004	4.5
Нийтийн АА, хөнгөн үйлдвэрлэлийн ажилтан	3966	8.9
Соёл урлагийн ажилтан	749	1.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2947	6.6
Байгаль хамгаалал, аялал жуулчлал	795	1.8
Эрчим хүч, уул уурхай, авто, төмөр замын мэргэжилтэн	1212	2.7
Нийт	44681	100.0

2.10 Авто замын барилга, засвар, ашиглалт, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалангийн мэргэжлийн ангиудын хувьд сургалтын лабортори, дадлагын газар бий болгох нь зардал өндөртэй тул зардал багатай мэргэжлийн анги нээх хандлага байна. Иймд мэргэжлийн



чиглэлийг харгалзан төсвөөс олгох хувьсах зардлын нормативыг ялгавартай тогтоох нь зүйтэй.

- 2.11 “Мэргэжлийн чиглэл тогтоох тухай” БСШУ-ны сайдын 2008 оны 461 дүгээр тушаалаар мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаар мэргэжилтэн бэлтгэхэд баримтлах сургалтын үндсэн болон бусад мэргэжлийн чиглэлийг зөвхөн төрийн өмчийн МСҮТ-үүдэд тогтоож, хувийн хэвшлийн сургуулиудыг орхисон байна.
- 2.12 МСҮТ төгсөгчдөөс мэргэжлийн ажил эрхэлж буй хүмүүсийн хувийн жин бага, ихэнх нь дээд сургуульд сурахын өмнөх шат болгож, тэтгэлэг авах сонирхол давалгайлж байна. Энэ талаар судалгаа, бүртгэл бий болгох шаардлагатай байна.

**Шинээр байгуулах “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан”-г, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-тай уялдуулж болохоор байна**

- 2.13 Боловсролын тухай хуульд зааснаар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр МСҮТ-үүдийн хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, Засгийн газрын 2007 оны 294 тогтоолоор батлагдсан “МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-аар суралцагчдад сар бүр 45.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгож байна.
- 2.14 2009 онд улсын төсвөөс МСҮТ-үүдийн санхүүжилтэд 30.8 тэрбум төгрөг зарцуулсны дотор 10.7 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгожээ.
- 2.15 2002 оны “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй, эмзэг бүлгийн иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах зардлыг ХЭДС-гаас гаргах тухай заалт байсан боловч 2009 онд шинэчлэн батлагдсан хуульд энэ заалт хасагдсан, харин МБСГ-ын удирдлага дор “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-г байгуулахаар заасан нь одоогоор журам боловсруулах шатандаа байна.
- 2.16 ХЭДС-гаас мэргэжил олгоход 2009 онд 2015.4 сая төгрөг зарцуулсан. МСҮТ-ийн суралцагчдад төсвөөс СТС-гаар дамжуулан олгож буй (цаашдаа шинээр бий болох Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас гарна) тэтгэлгийн зардлыг ХЭДС-гийн зарцуулалттай уялдуулах талаар яамд хамтарч ажиллах шаардлагатай байна.
- 2.17 Төрийн өмчийн МСҮТ-ийн нийт санхүүжилтийг Төрийн сангаас, хувийн хэвшлийн МСҮТ, коллеж, их, дээд сургуулийн анхан шатны ангид суралцагчдын санхүүжих хувьсах зардал болон тэтгэлгийг сургуулиудаас ирүүлсэн тооцоог үндэслэн улиралд нэг удаа СТС-гаас олгож байна.
- 2.18 МСҮТ-үүд Засгийн газрын 2007 оны 294 тогтоолоор батлагдсан “МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-д заасны дагуу сар бүрийн хүүхдийн тооны гүйцэтгэлээр тооцоо хийж үлдэгдлийг буцаан төвлөрүүлэх үүрэг хүлээдэг ч 2009 онд 11 сургууль 74.7 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлж, бусад сургууль тооцоо хийгээгүй байна.
- 2.19 Аудитын түүвэрт хамрагдсан зарим сургуулийн тэтгэлгийн тооцоог шалгахад дараахь байдалтай байна. Тухайлбал,

(сая төгрөгөөр)

Сургуулийн нэр	СТС-гаас санхүүжилт өгсөн санхүүжилт	Суралцагчдад олгосон тэтгэлэг	СТС-д буцаан төвлөрүүлсэн, тооцоогор суутгуулсан	сургуульд үлдсэн /төлбөрийн акт тогтоох/
Шинэ Иргэншил Дээд сургуулийн МСҮТ	110.6	108.9	1.7	-
Техник технологийн коллеж	618.8	561.2		57.6
Монгол фермер коллеж	87.8	87.1	0.7	-
“Монгол Бизнес” Дээд сургуулийн МСҮТ	21.6	21.6	0	0
Барилгын технологийн коллеж	502.7	499.3	1.1	2.3
Абука МСҮТ	153.0	151.1	0.7	1.2
Хүнсний технологийн коллеж	422.3	422.3	-	-
Фреш МСҮТ	72.8	72.8	-	-
Хангай коллеж	151.4	125.7	25.7	-
Дүн	2141.0	2050.0	29.9	61.1

2.20 МСҮТ-ийн санхүүжилтийг олгох, хяналт тавих нь СТС-гийн чиг үүрэгт хамаардаггүй, эрх зүйн актгүй тул хувьсах зардал болон тэтгэлгийн зарцуулалтыг шалгах боломжгүй гэсэн тайлбарыг өгч байна.

### **МСҮТ-ийн суралцагчдад тэтгэлэг олгох тухай журам тодорхой бус байна**

2.21 Хуульд зааснаар МСҮТ-д өдөр, орой, эчнээ хэлбэрээр суралцах боломжтой, тэтгэлэг олгох тухай журамд суралцагчдад тэтгэлэг олгох тухай ерөнхий зааснаас хөдөө мал малладаг, ЕБС болон хотод их, дээд сургуульд сурдаг хүүхдийг эчнээгээр бүртгэж тэтгэлэг, хувьсах зардал олгосон байна. Аудитын явцад МСҮТ-ийн сурагчдын тооллогыг нэг зэрэг хийхэд зарим зөрчил илэрлээ. Тухайлбал,

*Дундговь аймагт ЕБС болон их, дээд сургууль, коллежид өөр мэргэжлээр давхар сурдаг, элсэлтийн бичиг баримтгүй, 24 нас хүрсэн зэрэг 35 хүнд 14.5 сая төгрөгийн тэтгэлэг олгосон;*

*Баянхонгор аймгийн МСҮТ-д ЕБС-ийн 11-р ангид давхар сурдаг 24 суралцагчид 10.8 сая төгрөгийн тэтгэлэг олгосны дээр 67 хүүхдийн хувийн хэрэг, 17 хүүхдийн суурь боловсролын үнэмлэх дутуу;*

*Баянхонгор аймаг дахь Өлзийт МСҮТ суралцагчдын 72.3 хувь нь ЕБС-д, 13.7 хувь нь дээд сургуульд давхар сурдаг, 17 хүүхдийн суурь боловсролын үнэмлэх дутуу, бүх суралцагч хувийн хэрэггүй;*

*Дархан-Уул аймагт хүүхдийн тоог илүү төлөвлөж санхүүжилт авсан, хувьсах зардал тэтгэлгийн зөрүүг буцаан төвлөрүүлээгүй, сургуулиа орхисон, шилжсэн, тасалсан суралцагчид тэтгэлэг олгосон;*

*ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль үслэг эдлэлийн оёдолчин, эсгүүрийн анги нээж өөрийн бакалаврын сургалтын оюутнуудаар бүрдүүлсэн, хичээлд суугаагүй суралцагчид тэтгэлгийг сар бүр тогтмол олгосон;*

*Төв аймгийн Зуунмод суман дахь МСҮТ 7.5 сая төгрөгийн тэтгэлэг илүү олгосон;*

*Говь-Алтай аймгийн МСҮТ-д суралцагчийн тоог 1181-ээр төлөвлөж 837 сурсан, Булган аймгийн МСҮТ суралцагчийн тоог 945-аар төлөвлөж 498 хүүхэд сурсан нь төлөвлөлтийг үндэслэлгүй хэт өндөр хийснийг харуулж байна.*

2.22 Хувийн хэвшлийн МСҮТ-д хувьсах зардал болон тэтгэлэг олгох болсноос сурах орчин муутай сургууль нэмэгдэх хандлагатай байна. Үүнд Барилгын коллежийн дотуур байрны нэгдүгээр давхарт байрлах “Амьдрах ухаан” МСҮТ болон Хамаг монгол, Баз скүүл, Дүрслэх урлагийн Анима сургуулийг дурьдаж болно. Мөн хувийн хэвшлийн зарим МСҮТ-үүд санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлэхгүй байна.

### **Боловсролын салбарын төсвийн хэмнэлтийн журам хүүхдийн тоог өсгөж төлөвлөх сонирхол төрүүлэхүйц болжээ**

2.23 БСШУ-ны сайд, Сангийн сайдын 2009 оны 560/276 дугаар тушаалаар “Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ЕБС-ийн үдийн цай /хоол/, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТ, коллежид суралцагчдын тэтгэлгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг баталсан байна.

2.24 Уг журам нь суралцагчдын тооноос хамаарах зардлын зөрүүг төвлөрүүлснээр зориулалт бус зарцуулалтыг зогсоох, боловсролын салбарт гарч болзошгүй санхүүгийн эрсдэлийг БСШУ-ны сайдын хүсэлтээр Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан тушаалаар санхүүгийн жилд багтаан санхүүжүүлэх зорилготой.

2.25 Энэ журмыг үндэслэн БСШУЯ-ны хэмнэлтийн дансыг Төв төрийн санд нээж, 2010 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 2980.2 сая төгрөгийг төвлөрүүлж, зарлагын гүйлгээ хараахан хийгээгүй байна.

- 2.26 Уг хэмнэлтийн мөнгийг төвлөрүүлэхэд зориулан нээсэн тусгай данснаас гадна Сангийн яамны Төрийн сангийн газар “Чингэс хааны үндэсний хороо”-ны дансанд 2010 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 4 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл 106 удаагийн гүйлгээгээр 2.1 тэрбум төгрөг төвлөрүүлж, үндсэн данс руу нь хаасан байна.
- 2.27 ТБУСТХ-ийн 12.1.1-д Төсвийн ерөнхийлөн захирагч “Эрхлэх асуудлынхаа хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого, санхүүжилтийн хэрэгцээгээ бодитой тогтоох” гэснийг үндэслэн хэмнэлтийн журмыг баталжээ.
- 2.28 Төсвөө зөв, үндэслэлтэй төлөвлөх нь санхүүжилтийн хэрэгцээг бодитой тогтооход нөлөөлөх бөгөөд уг журам төлөвлөсөн хүүхдээ элсүүлж чадаагүйгээс түүний зөрүүгээр хэмнэлт гаргаж тусгай дансанд төвлөрүүлж байна.
- 2.29 Хэмнэлт гэдэг нь гарцын тоо, чанарыг бууруулахгүйгээр орцын өртгийг бууруулах явдал юм. Боловсролын салбарын суралцагчийн тооноос хамаарах нормативт зардлын хэмнэлт нь төлөвлөсөн тооны суралцагчдад чанарын шаардлага хангасан боловсролыг эзэмшүүлэхдээ гарах зардлыг багасгасан тохиолдолд үүсэх учиртай.
- 2.30 Уг журмын хэрэгжилтийн явцаас үзэхэд суралцагчдын тоог ихээр төлөвлөн төсөв батлуулж хэмнэлт гарган, төвлөрүүлэн зарцуулж болзошгүй журам болсон байна.
- 2.31 Тухайлбал, хэмнэлтийн дансанд хамгийн өндөр дүнтэй 159.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн Барилгын коллежийн 2010 оны 1-4 сарын гүйцэтгэлийг авч үзвэл дараахь байдалтай байна.

Зардлын зүйл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү		Хэмнэлтийн дансанд шилжүүлсэн
	Хүүхэд өдөр	дүн	Хүүхэд өдөр	дүн	Хүүхэд өдөр	Дүн	
ДБ-ны хоол	9900	10897.8	4877	4711.6	5023	6186.2	6186.2
Суралцагчдын тэтгэлэг	95700	289575.0	66715	136433.8	28985	153141.2	153141.2
<b>Дүн</b>	105600	300472.8	71592	141145.4	34008	159327.4	159141.2

- 2.32 Тус сургууль хүүхдийн тооноос хамаарах дээрх 2 зардалд батлагдсан төсвийн 47.0 хувийг зарцуулж, 53.0 хувийг хэмнэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.
- 2.33 Хэнтий аймгийн МСҮТ-д 2009-2010 оны хичээлийн жилд суралцагчийн тэтгэлгийг 1194 хүүхдээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 875 хүүхэд хамрагдан 323.4 сая төгрөгийн тэтгэлэг олгож, 122.2 сая төгрөг үлдсэн байна.

# ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:**

1. Хувьсах зардлын норматив, хүүхдийн тоонд үндэслэж хийсэн төсөв “Монгол Улсын төсвийн тухай” болон төсвийн тодотголоор танагддагаас хүүхдийн тоог өсгөж төлөвлөн төсвөө нэмэгдүүлэн батлуулах сонирхол сургуулиудад түгээмэл байна.
2. Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн төсөв хүрэлцэхгүй, санхүүгийн хүндрэл үүссэн байхад хувийн хэвшлийн байгууллагуудад жилийн эцэст тогтмол зардлаас нэмж олгосон нь санхүүгийн хяналт сул байгаатай холбоотой байна.
3. Засгийн газрын 2009 оны 190 дүгээр тогтоолоор 2010 оны төсвийн төлөвлөлтөд хэрэглэгдэх хувьсах зардлын норматив өмнөх оны нормативаас 11.6-13.6 хувиар буурсан, санхүүжилтийг оновчтой бус хуваарилснаас зарим сургуульд төсвийн хүндрэл үүсч байна.
4. ЕБС хувьсах зардлын нормативыг ашиглан төсвийн төлөвлөгөө хийдэг ч санхүүжүүлэхдээ гүйцэтгэлээр тооцдоггүй байна.
5. Боловсролын салбарт хүүхдийн хоолны зардлыг цогц шийдээгүйгээс ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалтай харьцуулахад тухайн насны хүүхдийн авах шаардлагатай илчлэг, шимт бодисын хэмжээнд хүрэхгүй байна.
6. Сүүлийн жилүүдэд хөдөөгийн сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч байгаа боловч хотын сургуулиудын сургалтын орчин, материаллаг бааз, хүчин чадлыг бэхжүүлэх ажил хангалтгүй байна.
7. 2009-2010 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид 164.8 мянган оюутан, МСҮТ-д 44.7 мянган суралцагч сурч байгаа нь мэргэжилтэй нэг ажилчинд 3.7 дээд боловсролтой мэргэжилтэн ногдохоор байна. Мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэхэд төрийн бодлогыг чиглүүлж өмчийн хэлбэр харгалзалгүй хувьсах зардлыг төсвөөс санхүүжүүлж, суралцагчдад сар бүр тэтгэлэг олгож байгаа боловч төсвийн хөрөнгийг эдийн засгийн тэргүүлэх салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил эзэмшүүлэхэд оновчтой зарцуулж чадаагүй байна. Үүнд дараахь хүчин зүйлс нөлөөлж байна:
  - Салбарууд ямар мэргэжлээр хэдэн хүн сургах хэрэгцээ шаардлагаа тогтоогоогүйгээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний нэгдсэн судалгаа байхгүй,
  - Хариуцсан яамд хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, ажлын уялдаа холбоо муу байгаа,
  - Төсвөөс олгож буй нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг мэргэжлийн онцлог, шинж байдлаас хамааруулж ялгавартай тогтоогоогүйгээс зардал бага зарцуулах үсчин, гоо сайхан, нарийн бичгийн дарга, нягтлан бодогчийн анги нээх сонирхол давамгайлдаг,
  - Сургууль төгсөгчдийн хэдэн хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажил эрхэлж байгаа талаар судалгаа хийгээгүй байна.

# ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт зөвлөмж болгож байна:**

1. Хувьсах зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тогтолцооны суурь болсон суралцагчид, багш, ажилтнуудын нэгдсэн бүртгэлийн систем, мэдээллийн сан бий болгох,
2. Хувьсах зардлын норматив боловсруулах аргачлалыг шинэчлэн боловсруулж, төсвийн төсөл боловсруулах, гүйцэтгэлийг тооцох үр дүнтэй систем бий болгож төсвийн төлөвлөлтийг бодитой болгох,
3. Цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн суралцагчдын хоолны зардлын нормативыг тогтоохдоо тухайн насанд шаардлагатай илчлэгийн хэмжээтэй уялдуулах, шардлагатай гэж үзвэл эцэг эхээс нь тодорхой зардлыг гаргуулдаг болох,
4. МСҮТ-ийн тэтгэлэг, хувьсах зардлын нормативыг тогтоохдоо хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжил эзэмшүүлж байгаа байдлыг харгалзан ялгавартай хандах,
5. Өндөр насны тэтгэвэрт гарах үеийн болон орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг төлөвлөж олгоход гарч буй зөрчлийг арилгаж, системийн хэмжээний мэдээллийн сүлжээ бий болгох
6. Үр нөлөөтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох
7. Хууль тогтоомж зөрчиж илүү төсөв батлуулсан, зориулалт бусаар зарцуулсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох

**Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт:**

1. ТБУСТ-хууль, 2009 оны улсын төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль зөрчиж санхүүжилтийг хууль бусаар төлөвлөсөн, зарцуулсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох



# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага Тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-24-80, Факс: (976-11) 32-51-58  
E-mail: mecs@mecs.gov.mn, http://www.mecs.gov.mn

2010.07.02 № 144071

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

“Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт,  
санхүүжилтийн үр нөлөөт байдал”-д хийсэн аудитын  
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Саналын зөрүүтэй ойлголтын өөрчлөлтийг  
засварлаж тайлбарыг хүргүүлж байна.

Саналыг хавсаргав.1 хуудас

САЙД



Ё.ОТГОНБАЯР

9 9051

“Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн үр нөлөөт байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх санал

ҮАГ-ын тайлбар 1	Аудитын тайлангийн 1.12-т “Боловсролын төсөв буурсан нь” гэж өгүүлбэрийн эхэнд нэмж оруулах.
ҮАГ-ын тайлбар 2	1.19-д “Салбарын мэдээллийн системийг сайжруулах ажлыг сүүлийн 2 жилд эрчимтэй шинэчилж нэгдсэн мэдээллийн баазыг 2010 онд дуусган хэрэглэж байгаа боловч хяналт хийж, хариуцлага тооцох механизм байхгүй байна” гэж найруулах.
ҮАГ-ын тайлбар 3	1.65, 1.68 дахь заалтуудын нэгтгэн найруулж засварлах.
ҮАГ-ын тайлбар 4	1.67-д “Төсөв батлах удаа дараагийн хэлэлцүүлэг болон төсвийн тодотголоор үндэслэлгүй бууруулсан нь тогтмол зардлын хэтрэлтэд зарим талаар нөлөөлсөн байна” гэж өөрчлөн найруулах.
ҮАГ-ын тайлбар 5	2.26 дахь заалтыг хасах.
ҮАГ-ын тайлбар 6	2.28 дахь заалтыг “Төсөв төлөвлөхөд нөлөөлөх гол нөхцөл болох хүүхдийн тоог төрөөс нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд тухайн хичээлийн жилд сургуулиуд төлөвлөсөн хүүхдээ элсүүлж чаддагүйгээс үүссэн хэмнэлтийг сангийн яамны төрийн сангийн хэмнэлтийн тусгай дансанд төвлөрүүлж байна” гэж өөрчлөх.
	<b>Дүгнэлтийн хэсэгт</b>
ҮАГ-ын тайлбар 7	1-д “2009, 2010 оны төсвийн тухай хуулийн хэлэлцүүлгийн явцад боловсролын салбарын төсвийг хасч баталсан нь сургууль, цэцэрлэгүүдэд зардал хүрэлцэхгүй байдал үүсч зарим сургуулиуд хүүхдийн тоог өсгөж төлөвлөх хандлагатай болсон байна” гэж өөрчлөн найруулах.
ҮАГ-ын тайлбар 8	3-д “УИХ-аас Боловсролын салбарын төсвийг бууруулсан нь төсөвтөө багтаан ажиллах зайлшгүй шаардлага тулгарсны дагуу Засгийн газрын 2008 оны 294 дүгээр тогтоолыг бууруулан 2009 оны 190 дүгээр тогтоолыг шинээр батлуулах үндэслэл болжээ. 2010 оны төсвийн төлөвлөлтөд хэрэглэх нормативыг өмнөх оныхоос 11.6-13.6 хувиар бууруулсан байна” гэж өөрчлөн найруулах.
ҮАГ-ын тайлбар 9	5-д “Боловсролын салбарт хүүхдийн хоолны зардлыг цогц шийдэх санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй байна. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалтай харьцуулахад тухайн насны хүүхдийн авах шаардлагатай илчлэг, шимт бодисын хэмжээнд хүрэхгүй байгаа тул хоолны зардлын нормативыг шинэчлэх шаардлагатай байна” гэж өөрчлөн найруулах.
ҮАГ-ын тайлбар 10	9-д “Салбарууд ямар мэргэжлээр хэдэн хүн сургах хэрэгцээ шаардлагаа тэгтоогоогүйгээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний нэгдсэн судалгаа айхгүй нь хүүхдийн элсэлтийн тоог нэмэгдүүлэн тооцох шалтгаан үндэслэл болж байна” гэж өөрчлөн найруулах.
ҮАГ-ын тайлбар 11	10-д “Нийгмийн хамгаалал хөдөлмөр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамдын хоорондын, ажлын уялдаа холбоо сул байгаа нь бодлогын өөрчлөлтийн хэрэгжилт удаашралтай байна” гэж найруулах саналтай байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

# ҮАГ-ЫН ТАЙЛБАР

Санал 1: Тайлангийн 1.8, 1.9-д саналыг тусгасан байгаа тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Санал 2: саналыг хүлээн авч найруулгын засвар хийлээ.

Санал 3: 1.65-д “тогтмол зардлын үнэ өссөн” гэж нэмлээ.

Санал 4: Хүлээн авч найруулгын засвар хийлээ.

Санал 5: Хэмнэлтийн мөнгийг “Чингэс хааны үндэсний хороо”-ны дансанд БСШУЯ бус Сангийн яамны Төрийн сангийн газар техникийн алдаа гаргаж оруулсан болохыг тайланд тусгасан тул хасах шаардлагагүй гэж үзлээ.

Санал 6: Саналыг хүлээн авч “төлөвлөсөн хүүхдээ элсүүлж чадаагүйгээс түүний зөрүүгээр хэмнэлт гаргаж тусгай дансанд төвлөрүүлж байна” гэж өөрчиллөө.

Санал 7: Саналд тусгасан засварыг хийснээр агуулга өөрчлөгдөхгүй тул шаардлагагүй гэж үзлээ.

Санал 8: Тайлангийн дүнд тодорхой тусгагдсан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санал 9: Уг асуудал зөвлөмжийн хэсэгт тусгагдсан байна.

Санал 10: Аудитын дүнгээс дүгнэлт нь урган гарсан тул засвар хийх боломжгүй байна.

Санал 11: Саналыг хүлээн найруулгын засвар хийв.

## 2009 оны Ерөнхий боловсролын сургуулиудын санхүүжилт

(сая төгрөгөөр)

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөсөн санхүүжилт		Нийт санхүү- жилтэ д эзлэх хувь	Гүйцэтгэлээр		Нийт санхүү- жилтэ д эзлэх хувь
		Нийт	Үүнээс: Хувьсах		Нийт	Үүнээс: Хувьсах	
1	Архангай	9,627,773.7	8,176,928.4	84.9	8,431,027.4	7,402,216.2	87.8
2	Баян Өлгий	11,038,454.5	7,772,796.9	70.4	11,038,454.5	7,772,796.9	70.4
3	Баянхонгор	9,167,226.5	7,244,859.4	79.0	8,396,167.1	6,744,066.8	80.3
4	Булган	5,307,859.1	3,910,584.4	73.7	5,233,642.2	3,794,967.9	72.5
5	Говь Алтай	7,341,337.5	4,537,294.2	61.8	7,214,091.6	4,537,294.2	62.9
6	Говьсүмбэр	1,383,442.2	1,046,635.6	75.7	1,381,784.1	1,054,060.8	76.3
7	Дархан Уул	8,226,114.5	6,087,136.3	74.0	7,352,351.0	5,601,058.3	76.2
8	Дорноговь	4,974,916.7	3,473,913.2	69.8	5,233,989.6	3,457,946.8	66.1
9	Дорнод	6,217,826.7	3,401,348.8	54.7	6,215,116.1	3,467,092.1	55.8
10	Дундговь	4,951,555.1	240,376.4	4.9	4,447,139.1	193,806.7	4.4
11	Завхан	7,683,557.2	5,676,775.0	73.9	8,219,713.0	6,286,911.0	76.5
12	Орхон	6,424,029.3	4,063,396.7	63.3	6,424,029.3	3,879,474.0	60.4
13	Өвөрхангай	10,229,302.6	8,119,746.1	79.4	9,282,288.7	7,524,808.7	81.1
14	Өмнөговь	4,933,983.3	2,393,737.7	48.5	4,875,655.4	2,253,821.1	46.2
15	Сүхбаатар	6,077,554.6	4,849,482.8	79.8	5,248,777.6	4,110,388.8	78.3
16	Сэлэнгэ	8,656,267.4	6,289,441.2	72.7	8,868,531.9	6,427,431.0	72.5
17	Төв	7,695,036.9	5,310,918.3	69.0	7,784,779.3	5,348,305.6	68.7
18	Увс	8,694,464.6	6,593,007.0	75.8	8,613,303.9	6,581,040.6	76.4
19	Улаанбаатар	55,097,779.0	41,236,809.5	74.8	52,829,857.8	40,633,809.1	76.9
20	Ховд	9,342,719.6	6,916,864.6	74.0	8,266,669.0	5,705,303.4	69.0
21	Хөвсгөл	11,361,144.7	10,055,868.5	88.5	11,326,806.1	10,120,008.1	89.3
22	Хэнтий	6,663,963.7	4,632,858.4	69.5	6,531,800.4	4,638,702.8	71.0
	<b>Нийт дүн</b>	<b>211,096,309.4</b>	<b>152,030,779.4</b>	<b>72.0</b>	<b>203,215,975.0</b>	<b>147,535,310.8</b>	<b>72.6</b>

## Ерөнхий боловсролын сургуулиудын 2009 оны хүүхдийн тооны төлөвлөлт

(хүнээр)

№	Аймаг, нийслэл	Бага анги		Хувь	Дунд анги		Хувь	Ахлах анги		Хувь	Нийт		Хувь
		төлөвлөсөн	гүйцэтгэлээр		төлөвлөсөн	гүйцэтгэлээр		төлөвлөсөн	гүйцэтгэлээр		төлөвлөсөн	гүйцэтгэлээр	
1	Архангай	10,908	10,860	100	7,600	6,888	91	2,926	2,456	84	21,434	20,204	94
2	Баян Өлгий	11,686	13,071	112	8,995	7,158	80	3,368	3,243	96	24,049	23,472	98
3	Баянхонгор	10,021	9,573	96	6,987	6,564	94	2,168	1,746	81	19,176	17,883	93
4	Булган	5,260	4,984	95	4,560	4,028	88	1,884	1,423	76	11,704	10,435	89
5	Говь Алтай	7,165	6,975	97	4,924	4,375	89	1,573	1,272	81	13,662	12,622	92
6	Говьсүмбэр	1,593	1,510	95	928	864	93	633	545	86	3,154	2,919	93
7	Дархан Уул	9,058	9,329	103	7,963	6,435	81	3,997	3,490	87	21,018	19,254	92
8	Дорноговь	5,333	5,944	111	4,581	3,869	84	1,524	1,190	78	11,438	11,003	96
9	Дорнод	7,333	7,184	98	5,400	5,337	99	2,249	2,068	92	14,982	14,589	97
10	Дундговь	4,853	4,894	101	3,526	3,353	95	996	808	81	9,375	9,055	97
11	Завхан	8,907	8,221	92	6,200	5,716	92	2,778	2,475	89	17,885	16,412	92
12	Нийслэл	90,204	94,252	104	64,228	56,262	88	29,125	31,733	109	183,557	182,247	96
13	Орхон	8,044	8,362	104	7,262	6,431	89	3,127	3,167	101	18,433	17,960	97
14	Өвөрхангай	12,536	12,647	101	9,197	8,447	92	2,949	2,641	90	24,682	23,735	96
15	Өмнөговь	5,649	5,601	99	4,135	3,890	94	1,433	1,058	74	11,217	10,549	94
16	Сүхбаатар	6,322	5,758	91	4,036	3,689	91	1,431	1,018	71	11,789	10,465	89
17	Сэлэнгэ	9,104	9,966	109	7,475	6,577	88	3,246	2,932	90	19,825	19,475	98
18	Төв	7,917	7,433	94	4,610	4,966	108	1,971	1,763	89	14,498	14,162	98
19	Увс	11,069	10,550	95	7,281	6,790	93	2,414	2,117	88	20,764	19,457	94
20	Ховд	10,918	10,505	96	7,700	6,972	91	2,927	2,663	91	21,545	20,140	93
21	Хөвсгөл	13,817	13,577	98	9,166	8,572	94	4,051	3,816	94	27,034	25,965	96
22	Хэнтий	8,244	7,695	93	5,467	5,095	93	1,943	1,500	77	15,654	14,290	91
23	Улаанбаатар	90,204	94,252	104	64,228	56,262	88	29,125	31,733	109	183,557	182,247	99
	<b>Нийт дүн</b>	<b>356,145</b>	<b>363,143</b>	<b>102</b>	<b>256,449</b>	<b>228,540</b>	<b>89</b>	<b>107,838</b>	<b>106,857</b>	<b>99</b>	<b>720,432</b>	<b>698,540</b>	<b>97</b>





МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн үр нөлөөт байдалд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2010 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Мөнхбаяр нарт зөвлөсүгэй.

Тав.Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070149

Монгол Улсын Ерөнхий Аудиторын  
2010 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн  
68 Тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Актын дугаар	Төлбөрийн дүн	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн (тегрөгөөр)
	Нэр	Албан тушаал					
1	Э.Намсрай	Техник технологийн коллежийн захирал	Тэтгэлэгийн зөрүүг зориулалт буссаар зарцуулсан	01/83	57,684,173.00		
2	Б.Ганбат	Техник технологийн коллежийн дэд захирал					
3	Б.Мөнхзул	Барилгын технологийн коллеж МСҮТ-ийн захирал	Тэтгэлэгийн зөрүүг	02/81	2,337,000.00		
4	Т.Болормаа	Барилгын технологийн коллеж МСҮТ-ийн нягтлан бодогч	зориулалт буссаар зарцуулсан				
5	Б.Мөнхзул	Абука МСҮТ-ийн захирал	Тэтгэлэгийн зөрүүг	02/80	1,204,757.00		
6	Т.Болормаа	Абука МСҮТ-ийн нягтлан бодогч	зориулалт буссаар зарцуулсан				
7	М.Тэмүүлэй	Юу Эс Ай мэргэжлийн сургуулийн гүйцэтгэх захирал	Санхүүгийн тайлан баланс гаргаагүй, тэтгэлэгийг хичээлд суусан цагаар тооцоогүй			01/75	64,800,000.00
8	Т.Урнаа	Монфрэнш МСҮТ, санхүү эрхэлсэн захирал	24-өөс дээш настай суралцагчдад тэтгэлэг олгосон	01/85	5,220,000.00		
	<b>Нийт дүн</b>			<b>4</b>	<b>66,445,930.00</b>	<b>1</b>	<b>64,800,000.00</b>